

“СОЛИД ТРЕЙД” ХХК
Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ-д

Улаанбаатар хот Баянгол дүүрэг 26-хороо Нарны
хороолол I-III тоот
Утас: +976 99116826
И-мэйл: anya1986.04@gmail.com

2024/3/26 № 40.
танай _____ № _____ т

Хүсэлт гаргах тухай

Хүсэлтийн шаардлага: Шинээр илэрсэн нөхцөл, байдлын улмаас анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг дахин хянуулах тухай.

Хүсэлтийн утга: “СОЛИД ТРЕЙД” ХХК-иас нэхэмжлэлтэй Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын дарга болон тус газрын Кадастрын Хэлтэст холбогдох “Ашигт малтмалын хайгуулын XV-021146 дугаартай тусгай зөвшөөрлийг цуцласан Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Геологи, Уул Уурхайн Кадастрын Хэлтсийн Даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 02 дугаартай шийдвэрээс “СОЛИД ТРЕЙД” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” шаардлагатай захиргааны хэргийг шийдвэрлэсэн Нийслэл дэх Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд

- ... “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн УУКК систем /CMCS/-д бүртгэлтэй хаягаас буцсан байхад ямар шалтгаанаар мэдэгдэл буцаагдсан болохыг шалгаагүй, ... Аж ахуйн нэгжийн хаягт өөрчлөлт орсон талаар Ашигт малтмал газрын тосны газар Кадастрын хэлтэст мэдээлэл өгөх гэсэн боловч тус компанийн гүйцэтгэх захирал Ш.Мижиддоржийн биеийн байдал хүнд байсан учир мэдэгдэж амжаагүй ...” гэж тайлбарлаж байна;
- Тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрдсэн тухай сонсох ажиллагааны мэдэгдлийг “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэлтэй хаягаар Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021 оны 12 сарын 3-ны өдрийн 8/5360 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч тус хаягт байхгүй байсан тул мэдэгдлийг буцаан гардуулсан байна;
- Нэхэмжлэгч Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.12 заасныг хэрэгжүүлж хаяг өөрчлөгдсөн талаарх мэдээллээ төрийн захиргааны байгууллагад бүртгүүлээгүйгээс мэдэгдлийг хүлээн аваагүй нь хариуцагчийг буруутгах үндэслэл болгохгүй;
- Иймд “... хариуцагч Захиргааны ерөнхий хуулийн 24, 25, 26 дугаар зүйлд заасан ажиллагааг тус тус явуулаагүй, хуулийг зөрчиж Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 02 дугаар шийдвэр гаргасан гэх нэхэмжлэгчийн үндэслэлийг хүлээн авах боломжгүй юм;
- Нэхэмжлэгч компанийн захирал өвчтэй болох нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар болон хэрэгт авагдсан шинжилгээний баримт, эмчийн

9/24

тодорхойлолт, эмнэлгийн магадлагаа зэргээр тогтоогдож байх боловч хуульд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээд тул тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж зөвхөн захирал төлбөр төлөх, хаяг өөрчлөгдсөнийг мэдэгдэх ёстой гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байх тул төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй, хаяг өөрчлөгдсөнийг мэдээгүйг Татварын ерөнхий хуульд заасан үндэслэлд хүндхэн үзэх шалтгаанд хамруулан үзэх боломжгүй байна;

- Нэхэмжлэгч XV-021146 дугаар тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй тул хариуцагчийн тусгай зөвшөөрлийг цуцалсан Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар шийдвэр Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т заасантой нийцжээ.
- Иймд “СОЛИД ТРЕЙД” ХХК-иас гаргасан Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар шийдвэрийн “СОЛИД ТРЕЙД” ХХК-д холбогдох эсэхийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг хэлэлцэхгүй болгож шийдвэрлэлээ.

гэж үзэж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тус шүүхийн 128/ЛШП2022/0290 дугаартай шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн Захиргааны Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 221/МА2022/0366 дугаартай магадлалд Хариуцагчаас хяналтын журмаар гаргасан гомдлыг Монгол Улсын Дээд Шүүхийн Захиргааны Хэргийн Танхимын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд

- 6. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээв;
- 13. Мөн хариуцагчаас Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана” гэж заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8/5360 дугаар албан бичгээр нэхэмжлэгчид тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрдсэн тухай мэдэгдлийг хүргүүлсэн боловч, хаягтаа байхгүй шалтгаанаар буцаагдсан тул хариуцагчийг хуульд заасан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэлгүй;
- 16. ... гэж зааснаар нэхэмжлэгч “СОЛИД ТРЕЙД” ХХК буюу хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан энэ тохиолдолд хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өвчтэй байсан нь хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үүргээ биелүүлэх боломжгүй байсан гэж үзэх үндэслэл болохооргүй байна.

гэж үзэж хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн тус шүүхийн 001/ХТ2022/0067 дугаартай тогтоол гарсан бөгөөд тус тогтоолыг дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл, байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлт гаргаж байна.

Холбогдох хууль зүйн эх сурвалж¹-ийг ашиглан, хүсэлтийн агуулгыг дараах асуудлын хүрээнд тодорхойлов. Үүнд,

¹ Хүсэлтэд хууль зүйн дараах эх сурвалжийг дор заасан хэлбэрээр ашиглав. Үүнд,

1. Зохицуулалтаас иш татсан,
 - 1.1. Компанийн тухай Хууль (цаашид “КтХ” гэх);
 - 1.2. Ашигт Малтмалын тухай Хууль (цаашид “АМтХ” гэх);
 - 1.3. Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай Хууль (цаашид “ЗХШХШтХ” гэх);

1. Сонсох ажиллагааны мэдэгдлийг цахим www.mrpam.gov.mn хуудсаар нийтлэж хүргээгүй тухай;
2. Тусгай зөвшөөрөл цуцласан мэдэгдлийг шуудангаар хүргүүлсэн тэмдэглэлгүй тухай;
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх боломжгүй байсан тухай;
4. Бусад.

НЭГ. Сонсох ажиллагааны мэдэгдлийг цахим www.mrpam.gov.mn хуудсаар нийтлэж хүргээгүй тухай.

Хариуцагчаас АМТХ-ийн 34.2-т заасан хугацаанд ашигт малтмалын хайгуулын XV-021146 дугаартай тусгай зөвшөөрлийн 4 дөх жилийн төлбөрийг төлөх үүргийг биелүүлээгүй тул тус хуулийн 34.6-д заасан алдангийг 34.7-д заасан хугацаанд төлөхгүй бол тусгай зөвшөөрөл цуцлагдах үндэслэл бүрдсэн талаар АМТХ-ийн 56.2-т зааснаар “СОЛИД ТРЕЙД” ХХК-д хаягласан мэдэгдлийг Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын <https://www.mrpam.gov.mn> цахим хуудаст 2021.11.19-2022.01.04-ний хооронд байршуулсан гэж шүүхэд тайлбарласан боловч тус мэдэгдэлийг ашигт малтмалын хайгуулын XV-021146 дугаартай тусгай зөвшөөрөл 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр дуусах хугацаанаас 19 хоногийн өмнө буюу 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан нь Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын <https://www.mrpam.gov.mn/news/2138> линкээр илэрхий байсныг 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр “СОЛИД ТРЕЙД” ХХК олж мэдсэн.

Үүнийг лавлахаар Ашигт “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 37 дугаартай албан бичгээр хандахад үүнийг баталж, Ашигт Малтмал Газрын Тосны Газрын 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 6/1092 дугаартай албан бичгээр хүлээн зөвшөөрсөн.

ХОЁР. Тусгай зөвшөөрөл цуцласан мэдэгдлийг шуудангаар хүргүүлсэн тэмдэглэлгүй тухай.

Хариуцагчаас тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тухай Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Геологи, Уул Уурхайн Кадастрын Хэлтсийн Даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаартай шийдвэрийг Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 8/34 дугаартай албан бичгээр мэдэгдэж, шуудангаар хүргүүлсэн үйл баримтыг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгсөн гэж тайлбарласныг шүүх хүлээн авч, анхан шатны шүүх Иймд “... хариуцагч Захиргааны ерөнхий хуулийн 24, 25, 26 дугаар зүйлд заасан ажиллагааг тус тус явуулаагүй, хуулийг зөрчиж Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 02 дугаар шийдвэр гаргасан гэх нэхэмжлэгчийн үндэслэлийг хүлээн авах боломжгүй юм. Нэхэмжлэгч XV-021146 дугаар тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй тул хариуцагчийн тусгай зөвшөөрлийг цуцласан Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар шийдвэр Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т заасантай нийцжээ. гэж дүгнэснийг хяналтын шатны шүүх хэвээр баталж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Гэтэл дээрх дүгнэлтийн үндэслэлийг нотлосон Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас 2022 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 8/34 дугаартай албан бичгийг

2. Зохицуулалтыг судалсан,
 2.1. Захиргааны Ерөнхий Хууль (цаашид “ЗЕХ” гэх).

шуудангаар хүргүүлсэн бүртгэл байхгүй байсан бөгөөд энэхүү үйл баримт нь Ашигт Малтмал Газрын Тосны Газрын 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 1/841 дугаартай албан бичгээр нотлогдож байна.

ГУРАВ. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх боломжгүй байсан тухай.

Хариуцагчаас ашигт малтмалын хайгуулын XV-021146 дугаартай тусгай зөвшөөрөлд холбогдуулан АМТХ-ийн 56.2-т зааснаар Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021 оны 12 сарын 3-ны өдрийн 8/5360 дугаартай албан бичгээр мэдэгдлийг “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн хаягаар хүргүүлсэн боловч тус компани хаягтаа байхгүй шалтгаанаар мэдэгдлийг хүлээн аваагүйд Хариуцагч буруугүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хаягийн өөрчлөлтийн мэдээллээ АМТХ-ийн 35.12-т зааснаар бүртгүүлээгүй бөгөөд тус компанийн гүйцэтгэх захирал хүнд өвчтэйн байсан ч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаягийн өөрчлөлтийг зөвхөн гүйцэтгэх захирал бус өөр этгээдээр бүртгүүлэх боломжтой байсан гэж тайлбарласныг шүүх хүлээн авч, анхан шатны шүүх *Тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрдсэн тухай сонсох ажиглалгааны мэдэгдлийг “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэлтэй хаягаар Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2021 оны 12 сарын 3-ны өдрийн 8/5360 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч тус хаягт байхгүй байсан тул мэдэгдлийг буцаан гардуулсан байна. Нэхэмжлэгч Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.12 заасныг хэрэгжүүлж хаяг өөрчлөгдсөн талаарх мэдээллээ төрийн захиргааны байгууллагад бүртгүүлээгүйгээс мэдэгдлийг хүлээн аваагүй нь хариуцагчийг буруутгах үндэслэл болгохгүй. Нэхэмжлэгч компанийн захирал өвчтэй болох нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар болон хэрэгт авагдсан шинжилгээний баримт, эмчийн тодорхойлолт, эмнэлгийн магадлагаа зэргээр тогтоогдож байх боловч хуульд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээд тул тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж зөвхөн захирал төлбөр төлөх, хаяг өөрчлөгдсөнийг мэдэгдэх ёстой гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байх тул төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй, хаяг өөрчлөгдсөнийг мэдээгүйг Татварын ерөнхий хуульд заасан үндэслэлд хүндхэн үзэх шалтгаанд хамруулан үзэх боломжгүй байна гэж дүгнэснийг хяналтын шатны шүүх 13. Мөн хариуцагчаас Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана” гэж заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8/5360 дугаар албан бичгээр нэхэмжлэгчид тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрдсэн тухай мэдэгдлийг хүргүүлсэн боловч, хаягтаа байхгүй шалтгаанаар буцаагдсан тул хариуцагчийг хуульд заасан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэлгүй. 16. ... гэж зааснаар нэхэмжлэгч “СОЛИД ТРЕЙД” ХХК буюу хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан энэ тохиолдолд хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өвчтэй байсан нь хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үүргээ биелүүлэх боломжгүй байсан гэж үзэх үндэслэл болохооргүй байна гэж хэвээр баталж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.*

Гэтэл дээрх дүгнэлтийн үндэслэл болсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, цахим шуудан, утас, факсын дугаар өөрчлөгдсөн мэдээллийг кадастрын бүртгэлийн системд бүртгүүлэх К-04 маягтыг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зөвхөн Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж бүртгүүлдэг байсан үйл баримтыг Ашигт Малтмал Газрын Тосны Газрын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 6/1340 дугаартай албан бичгээр нотлогдож байна.

Хаягийн мэдээллийн өөрчлөлтийг бүртгүүлэх К-04 маягтын мэдээллийн бүрдүүлбэрийн 5 дугаарт “ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр” гэж, тодорхойлолтыг үнэн зөв гаргасан гэх хэсэгт эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр, гарын үсэг зурахаар заасан нийтэд илэрхий үйл баримтаас үзвэл тухайн өөрчлөлтийн мэдүүлгийг дурын этгээд гаргах боломжгүй байна.

ДӨРӨВ. БУСАД

Х.Нямбаяр гэдэг хүнээс санал болгосны дагуу ашигт малтмалын хайгуулын XV-021146 дугаартай тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад анх удаа оролцож, 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөгийг улсад төлсөн бөгөөд үүний тулд арилжааны банкаас зээл авсанаар компани болон өрхийн эдийн засагт маш их дарамт болж, өрийн дарамтын улмаас цаашид ямар нэг үйл ажиллагаа явуулах огт боломжгүйд хүрсэн.

Улмаар зээлийн өрийн дарамтаас болж “СОЛИД ТРЕЙД” ХХК-ийн захирал Ш.Мижиддорж сэтгэл санааны эрүүл мэнд муудаж, 2 удаа цус харавсан бөгөөд одоо эрүүл мэнд улам муудаж, хорт хавдар оношлогдож, өөрийгөө бие даан авч явах чадваргүй болж, байнгын бусдын асаргаанд маш хүнд амьдарч байна.

Иймд хүсэлтийг хангаж шийдвэрлэн, шинээр илэрсэн нөхцөл, байдлын улмаас Монгол Улсын Дээд Шүүхийн Захиргааны Хэргийн Танхимын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 001/ХТ2022/0067 дугаартай тогтоол, Захиргааны Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 26-ний өдрийн 221/МА2022/0366 дугаартай магадлал, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 128/ШШ2022/0290 дугаартай шийдвэрийг тус тус хүчингүй болгож хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр буцааж өгнө үү.

ЖИЧ: Хүсэлтийг шийдвэрлэх шүүх хуралдаанд Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцох тул шүүх хуралдааны товыг мэдэгдэж, шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжоор хангаж өгнө үү.

ХАВСРАЛТ

1. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ 3 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН 6/1092 ДУГААРТАЙ АЛБАН БИЧГИЙН НОТАРИАТААР ГЭРЧИЛСЭН ХУУЛБАР, 1 ХУУДАСТАЙ;
2. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ 2 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН 1/841 ДУГААРТАЙ АЛБАН БИЧГИЙН НОТАРИАТААР ГЭРЧИЛСЭН ХУУЛБАР, 1 ХУУДАСТАЙ;
3. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ 3 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН 6/1340 ДУГААРТАЙ АЛБАН БИЧГИЙН НОТАРИАТААР ГЭРЧИЛСЭН ХУУЛБАР, 1 ХУУДАСТАЙ;
4. К-04 ТООТ МАЯГТЫН ХУУЛБАР, 1 ХУУДАСТАЙ.

НИЙТ 4 ХУУДАСТАЙ.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ: *Ш.Мижиддорж* Ш.МИЖИДДОРЖ

